

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 10 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгээс 2014 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2014 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөлд засаг захиргаа нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжийн буюу сумын онцлог, байршил зэргээс шалтгаалан ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор гэснийг 250 метрийн дотор гэж өөрчлөхөөр тусгажээ.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр, Д.Сарангэрэл, З.Баянсэлэнгэ, Г.Баярсайхан нараас Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатаас 2014 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй нэгтгэж хэлэлцүүлэх нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг 2012 онд батлагдсан хуулийн хэрэгжилт сайн байгаа учраас өөрчлөлт оруулах шаардлагагүй гэсэн саналыг тус тус гаргалаа.

Тус Байнгын хорооны хуралдаанаар Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Д.БАТЦОГТ